



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А193

Эг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 39 зүйлийн 39.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаанаас ойгоос мод бэлтгэх эрх авч мод бэлтгэсэн аж ахуй нэгж, ойн мэргэжлийн байгууллагуудын агуулахад байгаа модны үлдэгдэл тоолох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	Б.Мөнх-очир	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Нарийн бичгийн дарга:	Ч.Ундармаа	Сум дундын Ойн ангийн дарга
Гишүүд:	Г.Гантуяа	Сум дундын Ойн ангийн ойн инженер
	Б.Тулга	Онон багийн байгаль хамгаалагч
	Б.Мөнгөнтөгс	Цагдаа, Дэд ахлагч

2. Тооллогоог үр дүнтэй, хууль, эрх зүйн хүрээнд чанартай зохион байгуулж тайланг 2024 оны 06 дугаар сарын 18-ны дотор Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнх-очир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ГАНСҮХ

232401165